



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 01

Халбан

Чиглэл хүргүүлэх тухай

2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх талаар Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 02 дугаар албан тоот, Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 28 дугаар тогтоол, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар албан даалгаваруудын доор дурьдагдсан биелэлтийг багийн Засаг дарга нар, Мал эмнэлэг, Хөдөө аж ахуйн тасаг нар заасан цаг хугацаанд биелэлтийг хангаж ажиллахыг чиглэл болгож байна.

Нэг. Багийн Засаг дарга нарт

1.1. Сум багийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, ургац хураалт байгаль цаг уурын болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцож ажиллах

1.2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 28 дугаар тогтоолоор батлагдсан сумын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бэлтгэхэд онцгой анхаарах

1.3. Аюулгүйн нөөц болон малчид иргэдийн түвшинд бүрэн найрлагат хүчит тэжээлийн нөөцийг бүрдүүлэхэд тэжээлийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан үйлдвэрийн үнээр худалдан авах ажлыг зохион байгуулах

1.4. Бэлчээрийн даацад тулгууран улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжих хаваржих сумын малчин өрх, малын тоон судалгааг 9 сард багтаан гаргаж, холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч, гэрээний дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах

1.5. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу отор нүүдэл хийх малчин өрх, хүн амын судалгааг нарийвчлан гаргаж, отор нүүдлээр яваа малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай хүргэх, эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, яаралтай тусламжийн автомашины бэлэн байдлыг хангаж ажиллах

1.6. Худаг, уст цэг, өвөлжөө, хашаа, хорооны хүрэлцээ хангамжийн тооцоог сум, баг, малчин өрх бүрээр гаргах, малын хашаа хороог дулаалах, бууц нөөцлөх ажлыг өргөн хүрээгээр зохион байгуулах

1.7. Цаг агаарын хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалан зам, даваа хаагдах, халтиргаа гулгаа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг зохион байгуулах, автомашин, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах

1.8. Сумын удирдлагууд хадлан тэжээл бэлтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, малын үндэсний бүртгэл мэдээлэлийн нэгдсэн санд өвс, тэжээлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг өрх бүрээр Livestock.mofa.gov.mn программд шивж оруулах (Өрх бүрээр хадлангийн мэдээг хөдөө аж ахуйн тасагт гаргаж өгөх)

1.9. Ургац хураалтын үеэр талбайд мал оруулахгүй байх талаар малчид, тариаланчдын хариуцлагыг өндөржүүлж ажиллах

1.10. Гадны аймаг болон өөрийн аймгийн бусад сумын нутагт малчид отор нүүдэл хийхдээ 2 сумын Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний дагуу мал, амьтныг өөрийн сумын нутаг дэвсгэрээс гаргахдаа мал эмнэлгийн тасагт хандаж, бүртгүүлэн мал эмнэлгийн гэрчилгээ авч шилжилт хөдөлгөөн хийх (отор нүүдэл хийх малчдад мэдээлэл өгөх)

Хоёр. Мал эмнэлэгийн тасагт

2.1. Отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулан идэвхитэй болон идэвхгүй тандалт судалгааг тогтмол зохион байгуулах

2.2. Малчдын шилжилт хөдөлгөөнийг мал, амьтны халдварт өвчний эрсдэл бүхий бүс нутгаас хүлээн авахгүй байх талаар малчдад, иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээлэл, сэрэмжлүүлэг, сурталчилгааг тогтмол зохион байгуулах

2.3. Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулж мал эмнэлгийн дуудлага үйлчилгээний бэлэн байдлыг хангах

Гурав. Хөдөө аж ахуйн тасагт

3.1. Өвөлжих болон хэрэгцээлэх малыг бэлчээрийн даац, малын тарга хүч, хадлан тэжээлийн бэлтгэлийн байдал, сүргийн зохистой харьцаа зэрэгт тулгуурлан тогтоож сум, багийн хэмжээнд дүнг нэгтгэн боломжит хэмжээгээр эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг хурдан шуурхай зохион байгуулж мэдээ судалгааг Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх

3.2. Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр гаргаж байгаа инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн явц, чанар, өмчийн бүртгэлд хяналт тавих, сумын комисс газарт дээр нь хүлээн авч, эзэмшигчдэд хүлээлгэн өгөх

3.3. Бэлчээрийн ургамал хамгааллын ажлыг намрын технологит хугацаанд зохион байгуулж ажиллах

3.4. Мал үржүүлэг технологийн хавар, намрын технологит ажлыг график төлөвлөлтийн дагуу зохион байгуулан, хэрэгжилтийг хангах

3.5. Бог малын хээлтүүлэгчийг намар үзлэг ангилалтад хамруулж, орон түвшинд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог тооцож стандартын шаардлага хангахгүй хээлтүүлэгчийг үржлээс хасаж стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавих ажлыг эрчимжүүлэх

3.6. Үхэр сүргийн бүтэц, ашиг шимийг судалгаагаар өрхөөр гарган, ашиг шимийг хэрхэн сайжруулах талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах

3.7. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

3.8. Орон нутгийнхаа гол нэр төрлийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг статистикмэдээллийн цахим системд 7 хоног бүр шинэчлэн оруулж, үр дүнг тооцож ажиллах

3.9. Сүүний урамшуулалд 2024-2025 онд хамрагдах стандартын шаардлага хангасан сүүний үйлдвэр, цехийн хүсэлт, баримт бичгийн бүрдлийг хангуулж 09 дүгээр сарын 07-ны дотор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх

3.10. Үр тарианы сүрэл, тэжээлийн ургамлын иш, навч болон таана, хөмүүл, халгай, лууль зэрэг ургамлуудыг даршлах, гар тэжээл бэлтгэх арга, технологийг малчдад сургалтыг зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх

Дөрөв. Чандагат цаг уурын өртөөнд

4.1. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу малчид, иргэдэд түргэн шуурхай хүргэх

4.2. 2024-2025 оны өвөл, хаврын улирлын бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглалыг цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурлан бодитой тогтоох судалгааг танилцуулах

Албан даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж үр дүн, тайланг заасан хугацаанд тухайн байгууллагуудад хүргүүлэхийг ЗДТГ-ын дарга (Б.Бямбажав) – д даалгасугай.

ДАРГА



Н.АНХБАЯР